

ДЭЛХИЙН ЗАЛУУЧУУДЫН ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ГУРАВДУГААР СУДАЛГАА-2014

ТОВЧ ХУРААНГУЙ

Дэлхийн залуучуудын тамхины хэрэглээний үндэсний гуравдугаар судалгаа /ДЗХС/ нь 2014 оны 3-6 дугаар саруудад ДЭМБ, Америкийн Өвчин Судлалын Төвөөс хамтран боловсруулсан судалгааны нэгдсэн аргачлалыг хот болон хөдөө, орон нутгийн 13-15 насны 7-9-р ангийн нийт 7298 сурагчдыг хамруулан мөн тухайн судалгаанд хамрагдсан сургуулийн ажилтнуудаас сургуулийн тамхины бодлогын талаарх асуумж судалгааг авч үндэсний хэмжээнд нэгэн агшинд хийж гүйцэтгэлээ. Судалгаагаар Монгол улсад түгээмэл тохиолдож буй ХБӨ-ний нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийн нэг болох Залуучуудын тамхины хэрэглээний түвшинг тогтоох, тамхидалттай холбоотой өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хянах дэлхийн мэдээллийн санг бүрдүүлэх зорилготой бөгөөд энэхүү судалгааны ажлын хүрээнд дараахь зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

- Залуучуудын дундахь тамхи таталтын тархалтын хувийг хүйсийн ялгаатай байдлаар тогтоох,
- Тамхины хор хөнөөлийн талаархи сургуулийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрийн үр дүнг тодорхойлох,
- Залуучуудын тамхинаас гарах оролдлогын талаархи тэдний зан үйлийг тодруулах,
- Тамхины хэрэглээтэй холбоотой сөрөг зан үйлийн талаархи залуучуудын мэдлэг, хандлагыг тодорхойлох,
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан тамхинаас гаргах, оролдлогыг дэмжсэн сурталчилгааг нэмэгдүүлэх,
- Тамхины хэрэглээг тодорхойлох, тамхигүй орчинг бүрдүүлэх,
- Тамхин бүтээгдэхүүн авах боломж, хүртээмжийг үнэлэх, тамхины хүртээмж, дам тамхидалтыг багасгах зөвлөмж боловсруулах зэрэг болно.

“Дэлхийн Залуучуудын Тамхины Судалгаа” нь бүсийн орнуудад ашиглаж буй нэгдсэн аргачлалын дагуу Монгол улсын хэмжээнд төлөөллийн тэнцвэртэй байх зарчмыг харгалзан хот хөдөөгийн нийт 60 сургуулийг санамсаргүйгээр сонгосон. Судалгаанд нийт 7298 сурагч оролцох боломжтой байсанаас 6178 сурагчдын судалгааны бүрэн мэдээлэлд хяналт цэвэрлэгээ хийж, жинлэн улмаар статистикийн боловсруулалтыг хийсэн болно.

Тамхины хэрэглээ. Судалгаагаар одоогоор тамхи таталтын тархалтын байдал 14.3 хувьтай байгаа бөгөөд үүнээс эрэгтэй сурагчдын (20.3%) эзлэх хувь нь эмэгтэйгээс (8.3%) даруй 2 дахин их байна. Мөн судалгаанд хамрагдсан залуусын 45.0 хувь, үүнээс хөвгүүдийн 56.7 хувь, охидын 33.9 хувь нь тамхийг татаж үзсэн байгаа нь эрсдэл бүхий зан үйлтэй байгааг илтгэж байна. Дээрх үзүүлэлтийг утаат болон утаагүй тамхин бүтээгдэхүүний хэрэглээгээр нь ялгаатай байдлаар авч үр дүнг тодрууллаа. Үүнд:

Утаат тамхи: Нийт залуучуудын 5.6 хувь нь, үүнээс хөвгүүдийн 8.2 хувь, охидын 2.9 хувь нь одоогоор тамхи татаж байна. Мөн залуучуудын 3.9 хувь, үүнээс хөвгүүдийн 5.9 хувь, охидын 1.9 хувь нь одоогоор янжуур тамхи татаж байна.

Залуучуудын хувь 0.6, үүнээс хөвгүүдийн 1.2 хувь, охидын 0.1 хувь нь одоогоор байнга янжуур тамхи татаж байна. Мөн бусад төрлийн тамхин бүтээгдэхүүний

хэрэглээний одоогийн байдал дундажаар 3.6 хувьтай үүнээс хөвгүүдийн 5.0 хувь, охидын 2.0 хувьтай байна.

Судалгаанд хамрагдагсдын 18.5 хувь, үүнээс хөвгүүдийн 26.1 хувь, охидын 11.0 хувь нь ямар нэг хэмжээгээр тамхийг татаж үзсэн байна. Тухайлбал тэдний 15.6 хувь, үүнээс хөвгүүдийн 22.9 хувь, охидын 8.5 хувь нь янжуур тамхийг татаж үзсэн буруу дадалтай байна. Мөн залуучуудын 9.6 хувь үүнээс хөвгүүдийн 13.0 хувь, охидын 6.1 хувь нь янжуураас бусад төрлийн тамхи татаж үзсэн байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.

Утаагүй тамхи: Судалгаанд хамрагдсан залуучуудын 9.5 хувь, хөвгүүдийн 13.6 хувь, охидын 5.7 хувь нь одоогоор утаагүй тамхи татаж байна.

Тамхинд өртөмхий байдал: Судалгаагаар ирээдүйд тамхины хэрэглээнд өртөх магадлалтай өмнө нь тамхи татаж үзээгүй сурагчдыг тодруулахад тэдний 25.6 хувь үүнээс хөвгүүдийн 34.5 хувь, охидын 20.2 хувь нь ямар нэг хэмжээгээр цаашид өртөх магадлалтай гэсэн хариултыг өгсөн байна.

Янжуур тамхи татах нь тааламжтай гэж боддог одоогоор тамхи татаж үзээгүй сурагчдын байдал нийт судалгаанд хамрагдагсдын 8.1 хувь байгаа бөгөөд үүнээс хөвгүүдийн 8.6 хувь охидын 7.7 хувь нь тааламжтай гэсэн сөрөг хандлагатай байна.

Тамхины хор нөлөөний талаар хичээлээр үзсэн эсэхийг судлахад 10 сурагч тутмын 4 нь энэ талаар хичээл заалгасан бөгөөд 21.8 хувь нь тэдний насны хүүхдүүд яагаад тамхи татаж байгаа талаар ярилцсан байна. Сурагчдын 37.2 хувь нь тамхины хортой, сөрөг нөлөөллийн талаар, тухайлбал шүд шарладаг, үрчлээ үүсдэг, эвгүй муухай үнэр үнэртдэг талаар хичээлээр үзсэн байна.

Сүүлийн нэг жилд тамхи татдаг 10 сурагч тутмын 9 нь тамхиа хаяхыг хүссэн, 10 сурагч тутмын 8 нь тамхиа хаяхаар оролдсон байна. Эрэгтэй сурагчид тамхиа хаях оролдлогыг илүү хийсэн бөгөөд үүнийгээ өөрсдийнхөө эрүүл мэндийг сайжруулахын тулд хэмээн хариулжээ.

Сүүлийн 7 хоногийн хугацаанд судалгаанд хамрагдсан сурагчдын 54.4 хувьд тэдний дэргэд болон гэрт нь хэн нэгэн хүн тамхи татсан байна. Мөн судалгаанд оролцсон сурагчдын 79.1 хувь нь нийтийн үйлчилгээний газарт тамхи татахыг бүрэн хориглох хэрэгтэй, тамхи татахыг хориглосон хууль хэрэгждэггүй гэж үзсэн. Ойролцоогоор 10 оюутан тутмын 9 нь (88.0 хувь) тамхи татах нь тэдний болон бусдын эрүүл мэндэд нөлөөлнө гэж үзсэн байна. Судалгаанд хамрагдсан сурагчдын эцэг эхийнх нь нэг эсвэл хоёулаа татдаг гэж 54.5 хувь нь хариулсан бол, тэдгээр сурагчдын найз нөхдийн ихэнх нь эсвэл бүгд тамхи татдаг гэж зөвхөн 6.4 хувь нь хариулсан байна.

Судалгаанд хамрагдсан сурагчдаас “Тамхи татдаг хүн илүү найз нөхөдтэй байдаг эсэх” талаар тодруулан судлахад эрэгтэй 21.4 хувь, эмэгтэй сурагчдын 19.5 хувь “ТИЙМ” гэсэн хариултыг өгсөн байна. Цаашилбал, эрэгтэй 3.7 хувь нь, эмэгтэй сурагчдын 0.7 хувь буюу бага хэсэг нь тамхи татаж буй хүн илүү сонирхол татсан харагддаг гэж боддог сөрөг зан үйлтэй байна.

Судалгаанд хамрагдсан сурагчдын 10 хүүхэд тутмын 7 нь буюу 71.4 хувь нь тамхины эсрэг сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр үзсэн, 10 хүүхэд тутмын 6 нь зар сурталчилгааны самбар дээр гарсан тамхи болон тамхины сурталчилгааг харсан, 10 сурагч тутмын 4 нь тамхины сурталчилгааг сонин сэтгүүлээс үзсэн байна. Мөн судалгаанд оролцсон сурагчдын 9.9 хувьд нь тамхины брендийн лого бүхий ямар нэгэн эд зүйл байдаг.

Тамхи худалдан авах боломж хир байдаг талаар судалж үзэхэд сурагчдын 81.1 хувь нь ойролцоох дэлгүүрээс (эрэгтэй 79.6 %, сурагчдын 83.5 %) авдаг ба

тэдний, 8.0 хувь нь гэртээ тамхи татдаг, 2.3 хувь нь олон нийтийн газар тамхи татдаг байна. Одоогоор тамхи татдаг сурагчдын 85.8 хувь нь дэлгүүрээс хэдэн настайгаас хамаарахгүй, саадгүйгээр тамхийг худалдаж авдаг байна.

Эцэст нь, Залуучуудын дундахь тамхи таталтын тархалтыг 2003 оны судалгааны дүнтэй харьцуулбал тамхи таталтын тархалт 15 хувиар буурсан байна. Монголын залуучууд бусад улсуудын адил ялангуяа эрэгтэй сурагчид эмэгтэйгээс илүү ихээр тамхи татдаг өндөр эрсдэл хэвээр байна. Тамхины утаа орчны бохирдолд хортойгоор нөлөөлөх бөгөөд сурагчдын талаас илүү нь тамхи татдаг хүмүүстэй хамт амьдардаг ба тамхины утаатай олон нийтийн газруудаар явдаг, хоёр хүүхэд тутмын нэгнийх нь эцэг эхийн аль нэг нь тамхи татдаг байна.

Судалгаанд хамрагдсан арван сурагч тутмын нэг дам тамхидалт буюу бусдын татсан тамхины утаа тэдэнд хортойг мэддэг, найм болон олон нийтийн газар тамхи татах явдлыг хориглох ёстой гэж боддог байна. Тамхи татдаг залуучуудын тал орчим хувь нь тамхинаас гарахыг хүсдэг байна.

Судалгаанд оролцсон 10 сурагч тутмын 7 нь тамхины хортой нөлөөний талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сүүлийн сард мэдээлэл авсан, 6 нь рекламны самбараас, арван сурагч тутмын дөрөв нь сонин, сэтгүүлээс тамхины сурталчилгаа үзсэн гэжээ.

Судалгааны дүн нь Монгол улсын өсвөр насны залуучуудын дунд тамхи таталтын түвшинг тогтоосон урьд хийгдсэн судалгаатай харьцуулах тоон мэдээлэл болж байна.

Судалгаа нь тамхи таталтын тархалтыг үндэсний хэмжээнд харьцуулан судлах, үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх, өвчлөлөөс сэргийлэх, хянах, тандалтын тогтолцооны мэдээллийн сан бүрдүүлэх улмаар нийгмийн эрүүл мэндийн нотолгоонд суурилсан үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргах үндсэн үзүүлэлт болно.

ДДЗТХС-НЫ ЗОРИЛТУУД

Дэлхий дахины залуучуудын тамхины судалгаа (ДДЗТС) нь Дэлхий нийтийн Тамхины Тандалтын Тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд залуучуудын тамхины хэрэглээг (утаатай ба утаагүй) системтэйгээр хянах, тамхины хяналтын гол үзүүлэлтүүдийг судлах дэлхийн стандарт судалгаа юм.

ДДЗТХС нь 13-15 настай сурагчдын сургуульд суурилсан үндэсний хэмжээний судалгаа бөгөөд тухайн орныг төлөөлөх нэгэн агшны тоо баримтыг бий болгохоор зохион байгуулагдаж байгаа болно.

ДДЗТХС нь үндсэн асуумж, түүврийн арга, мэдээлэл цуглуулах стандарт аргачлалыг ашигладаг. Энэ нь улс орнуудад Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын Тамхины Хяналтын Суурь Конвенци (ТХСК)-оор хүлээсэн үүргээ биелүүлж улс орны хэмжээнд болон бусад улстай харьцуулах боломжтой мэдээлэл бий болгоход нь тусалдаг.

ДЭМБ нь MPOWER гэсэн сэдвийн дор ДЭМБ-ын ТХСК-ийн хэрэгцээг бууруулах сонгогдсон арга хэмжээнүүдийн багцыг боловсруулсан. Үүнд:

MPOWER

Тамхины хэрэглээ болон урьдчилан сэргийлэх бодлогыг хянах
Хүмүүсийг тамхины утаанд өртөж хордохоос хамгаалах
Тамхиа хаяхад нь туслахыг санал болгох
Тамхи хор хөнөөлтэй болохыг анхааруулах
Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны хоригийг хэрэгжүүлэх
Тамхин бүтээгдэхүүний татварыг нэмэгдүүлэх

Судалгааны арга зүй, аргачлал

ДДЗТХС нь сургуулиудыг суралцагчдын тоог харгалзан пропорционалаар сонгох хоёр үе шаттай түүвэрлэлт бүхий дэлхий дахины нэгдсэн стандарт арга зүйг ашигладаг. Сонгогдсон сургуулиас ангиудыг санамсаргүйгээр сонгох ба сонгогдсон ангийн бүх суралцагчдад судалгаанд оролцох боломжийг олгоно. Судалгаанд дэлхий нийтэд ашиглаж буй үндсэн стандарт асуумж ашиглах ба асуумж нь сонголтын бүлэг асуултуудыг агуулах ба эдгээр асуултууд нь тамхины хэрэглээ, тамхины хяналтын гол үзүүлэлтүүдийн талаарх тухайн улсын хэрэгцээг хангахуйцаар тохируулан хэрэглэх боломж олгоно.

**МОНГОЛ УЛС, (13-15 НАСНЫ) ҮНДЭСНИЙ СУДАЛГАА
ДЭЛХИЙН ЗАЛУУЧУУДЫН ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ СУДАЛГАА
(ДЗТХС) БАРИМТЫН ЦОМОГ**

Дэлхийн залуучуудын тамхины хэрэглээний судалгаа нь үндэсний хэмжээнд 2014 оны 3-6 саруудад ДЭМБ, Америкийн Нэгдсэн Улсын Өвчин Судлалын Төвөөс боловсруулсан судалгааны аргачлалын дагуу Улаанбаатар хот болон хөдөө, орон нутгийн 13-15 насны сурагчид, сургуулийн тамхины бодлогын судалгааг сургуулийн ажилтнуудыг оролцуулан хамруулан хийж гүйцэтгэсэн нэгэн агшны үндэсний 3 дугаар судалгаа болно. “Дэлхийн Залуучуудын Тамхины Судалгаа”-ны аргачлалын дагуу

улсын хэмжээнд төлөөллийн тэнцвэртэй тоог харгалзан уг судалгаанд 60 сургуулийг сонгосон. Судалгаанд хамрагдалтын ерөнхий түвшин: Судалгаанд нийт 60 сургууль сонгогдсоноос 100.0%, 266 анги сонгогдсоноос 100.0%, нийт 7911 сурагч хамрагдсанаас 7298 нь судалгааны асуумжийг бүрэн хариулсан хамрагдалт 92.3% байна.

Нийт хамрагдалтын түвшин:
 $100.0% * 100.0% * 92.3% = 92.3%$

ТАМХИ ТАТАЛТЫН ТАРХАЛТ	ДҮГНЭЛТ
<p>Нийт сурагчдын 14.3%, хөвгүүдийн 20.3%, охидын 8.3% одоогоор ямар нэгэн тамхин бүтээгдэхүүн хэрэглэж байна. Нийт сурагчдын 5.6%, үүнээс хөвгүүдийн 8.2%, охидын 2.9% одоогоор тамхи татаж байна.</p> <p>Нийт сурагчдын 3.9%, хөвгүүдийн 5.9%, охидын 1.9% одоогоор янжуур тамхи татаж байна.</p> <p>Нийт сурагчдын 9.5%, хөвгүүдийн 13.6%, охидын 5.7% одоогоор утаагүй тамхи хэрэглэж байна.</p>	<ul style="list-style-type: none"> • 5 сурагч тутмын 1 нь ямар нэгэн тамхин бүтээгдэхүүн хэрэглэдэг, 10 сурагч тутмын 1 ээс илүү нь бусад тамхин бүтээгдэхүүн хэрэглэдэг, 10 сурагч тутмын 1 нь одоогоор тамхи татдаггүй боловч дараа жилээс тамхи татаж магадгүй байгаа • Сурагчдын талаас илүү хувь нь гэртээ бусдын татсан тамхины утаанд өртдөг, сурагчдын 55,5% нь олон нийтийн газар тамхины утаанд өртдөг, тэдний эцэг эхийн нэг нь эсвэл хоёулаа тамхи татдаг • 10 сурагч тутмын 9 нь бусдын татсан тамхины утаа тэдэнд хортой гэж боддог • 10 сурагч тутмын 8 нь олон нийтийн газар тамхи татахыг хориглох ёстой гэж боддог
<p align="center">МЭДЛЭГ ХАНДЛАГА</p> <p>Сурагчдын 36.4% нь бусдын тамхи таталт өөрсдөд нь хортой болох тухай бодож байсан.</p> <p>Сурагчдын 90.3% нь хаалттай олон нийтийн газар тамхи татахыг хориглохыг дэмждэг.</p>	
<p align="center">БОЛОМЖ, ХҮРТЭЭМЖ – ОДООГООР ТАМХИ ТАТДАГ СУРАГЧИД</p>	
<p>Янжуур тамхи татагчдын 70.4% нь тамхиа дэлгүүр, гудамжны худалдаачин, ТҮЦ-нээс авдаг. Тамхи худалдан авсан тамхи татдаг сурагчдын 51.4%-д тэднийг тамхи худалдан авах үед насыг хэн нэгэн огт харгалзан үзэхгүйгээр худалдаалсан байна.</p>	
<p align="center">ДАМ ТАМХИДАЛТ</p> <p>Сурагчдын 42.4% нь гэртээ тамхины утаанд өртөж байсан байна.</p> <p>Сурагчдын 49.8% нь хаалттай олон нийтийн газар тамхины утаанд өртөж байсан байна.</p>	

ТАМХИА ХАЯХ ОРОЛДЛОГО

Тамхи татдаг 10 сурагч тутмын 8 нь сүүлийн 12 сард тамхинаас гарах оролдлого хийсэн байна. Тамхи татдаг 10 сурагчийн 8 нь тамхинаас гарахыг хүсдэг байна.

СУРТАЛЧИЛГАА

10 сурагчийн 6 нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр тамхины эсрэг сурталчилгааг харсан.

10 сурагчийн 1 нь тамхи худалдаалж буй газарт тамхины зар сурталчилгаа, тамхины хэрэглээг дэмжсэн сурталчилгааг харсан.

10 сурагчийн 1-д тамхины брэндийн лого бүхий ямар нэгэн зүйл байдаг.

- 10 тамхи татдаг сурагч тутмын 9 нь тамхиа хаяхыг хүсдэг
- 10 сурагч тутмын 7 оос илүү нь сүүлийн 30 хоногт тамхины эсрэг сурталчилгаа үзсэн,
- 10 сурагч тутмын 6 нь сүүлийн 30 хоногт тамхины сурталчилгаа бүхий гудамжны самбар харсан,
- 10 сурагч тутмын 4 нь сонин сэтгүүл дээрээс тамхины сурталчилгааг харсан .